



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу-15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0066

Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809

E-mail: contact@ub-procurement.mn

<http://www.ub-procurement.mn>

2019.07.05

№

01/929

танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭГДСЭН ТӨВД**

Тус газарт нийт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн эхний хагас жилийн тайланг 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3. хуудастай.

ДАРГА



Э.БОЛОРМАА

**НХААГ-Т ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар)

2019 оны 07 дугаар сарын 03

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ

“Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16, 23-ны өдрийн хуралдаан болон Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, түүний үр дүнг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ болон ажил хариуцсан албан хаагчийн тайлбарыг үндэслэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой дээрх үүрэг даалгаврын хүрээнд ажил төлөвлөж, зохион байгуулж буй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ХОЁР. ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Тайлант хугацаанд тус газрын албан хаагчдаас суралцах болон эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөө авах тухай 23 удаагийн өргөдөл, хүсэлт ирүүлснийг www.egr.ulaanbaatar.mn системд бүртгэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 44 минут байна.

Шийдвэрлэлтийн хугацаагаар авч үзвэл:

НИЙТ	5 хоногт	10 хоногт	15 хоногт	30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн
23	14	4	0	4	0	1

Шийдвэрлэлтийн зөрчлийн хувьд:

№	Хэлтэс	Өргөдлийн дугаар	Зөрчлийн дэлгэрэнгүй	Давтамж	Зөрчлийн огноо
1	Худалдан авах ажиллагааны хэлтэс	O190523072	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	1	2019-05-28
2	Мэдээллийн технологийн хэлтэс	O190523072	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	2	2019-05-24 2019-07-02
3	Хуулийн хэлтэс	M190211003	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо	2	2019-03-01 2019-04-01

2.2. Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д “Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана” гэж заасан. Уг заалтын хүрээнд хамаарах гомдол, өргөдөл тус газарт ирээгүй байна. Мөн уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-т “Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөний хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 хоногийн дотор гаргана” гэж заасан. Иймд тус газрын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгжээс гомдол ирээгүй тул энэ чиглэлээр тусгайлсан төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ үүсээгүй байна.


2.3. 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Газрын даргын А/20 дугаар тушаалаар байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан бөгөөд Өргөдөл гомдлын нэгдсэн системийг журмын дагуу хөтлөн, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэхээр тусгасан байна. Гэвч тайлант хугацаанд өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн дундаж хугацаа нь төлөвлөсөн хугацаанаас 2 өдрөөр хоцроон шийдвэрлэсэн дүнтэй байна.

Үүний шалтгааныг авч үзвэл, 30 хоногт шийдвэрлэсэн 4 өргөдлийн хувьд өдөрт нь багтаан хүлээн аваагүй, хавсралт дутуу оруулсан, шийдвэрлэлтийг системд бүртгэхдээ зөв бичгийн дүрмийн алдаа гаргасан зэрэг алдаа гаргасан байна.

ГУРАВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ


3.1. 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар тус газар нь 23 удаагийн өргөдөл, гомдлыг дунджаар 7 хоног 44 минутад багтаан шийдвэрлэж ажилласан байна. Цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг ажлын 5 хоногт багтаан бууруулах болон өргөдөл гомдол ирсэн өдөрт нь багтаан танилцах, шийдвэрлэлтийг цахим системд бүртгэхдээ Монгол хэлний зөв бичгийн дүрмийг баримтлахад анхаарах нь зүйтэй байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА




Э.БОЛОРМАА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



С.ОЮУНЦЭЦЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.ЖАРГАЛМАА

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ӨРГӨДӨЛ
ГОМДЛЫН ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 24

Улаанбаатар хот

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар тус газарт нийт 24 өргөдөл гомдол ирсэн байна. Өргөдөл гомдлыг ирсэн даруйд нь бүртгэн авч газрын даргаар цохолт хийлгэн Нийслэлийн өргөдөл гомдлын нэгдсэн систем болох Erp.ulaanbaatar.mn цахим хуудсанд бүртгэн оруулж хариуцах мэргэжилтэнд хүргүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.


а/ Өргөдөл гомдлын дэлгэрэнгүй тайлангийн хувьд авч үзвэл:

Хугацаандаа шийдвэрлэсэн 24, Хугацаа дөхсөн өргөдөл 0, Хугацаа хэтэрсэн-0 үзүүлэлттэй байна. Үүнээс

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь
1	Цалинтай чөлөө хүсэх тухай	4	18%
2	Цалин, хөлсний тухай	2	9%
3	Жирэмсний бөгөөд хүүхэд асрах чөлөөтэй	4	18%
4	Зэрэг дэв, зэргийн дэвийн нэмэгдлийн тухай	1	4.5%
5	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	2	9%
6	Ээлжийн амралтын тухай	3	13.5%
7	Чөлөөлөх тухай	7	31.5%
8	Тусламж хүсэх тухай	1	4.5%
Нийт өргөдөл, гомдлын дүн		24	100.00%

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа : 6 хоног 19 цаг 35 минут

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Э.БОЛОРМАА

ТАЙЛАН ГАРГАСАН:
БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ



Г.БАЯРБАДРАХ